

ОРХОН АЙМГИЙН ХӨТӨЧ НОМ



ОРХОН

АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА МЭДЭЭЛЭЛ

Зууны манлай бүтээн байгуулалт Эрдэнэт хот “Эрдэнэтийн овоо”-ны арын сайхан хөндийд 1973 онд шаваа тавьж, 1974 оноос Булган аймгийн Эрдэнэт хороо нэртэйгээр засаг захиргааны нэгжийн хувьд үүсгэн байгуулагджээ. Хурдан тэлж, хүн ам нь огцом өссөн тул хороог 1976 онд Эрдэнэт хот болгон зохион байгуулснаар Монгол улсын гурав дахь том хот болж, хөгжлийнх нь шинэ үе эхэлсэн юм. Нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжийн өөрчлөлтөөр 1994 онд “Орхон аймаг” болжээ.

Аймгийн төв: Эрдэнэт хот

Хэдэн сумтай: 2

Нутаг дэвсгэрийн хэмжээ: 84,4 мянган га

Аймгийн нийт хүн ам: 107,634 (2020 он)

Гадаадад оршин суугаа 4,113 хүн, гаднаас оршин суугаа 509+2 хүн

Үндэс Угсаа: Халх, Казах, Дөрвөд, Баяд, Буриад, Захчин, Дарьганга, Урианхай,

Дархад,

Өөлд, Хотогойд, Торгууд, Хотон, Мянгад

Малын тоо толгой: 136,990 (2020 он)

Утасны код: +976 7035 (7039)

Шуудангийн дугаар: 61020

Техникийн улсын дугаар: ОР

Цахим хуудас: www.erdenet.mn

Нийт нутаг дэвсгэрийн 50,2 мянган га нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 25,1 мянган га нь хот, тосгоны суурин газар, 24,7 мянган га нь ойн сан юм. Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 5300 га нь тариалангийн талбай, 33700 га нь бэлчээр юм. уулархаг, өмнөд хэсэг нь тал хөндий бөгөөд Багабогд, Арцбогд уулууд оршдог.

Өвөрхангай аймгийн нутгаар Орхон, Онги, Таац, Ар агуй зэрэг том голууд урсах бөгөөд Найман нуур, Таацын Цагаан нуур зэрэг нууруудтай.



ЭРДЭНЭТ

ХОТЫН ТУХАЙ



Эрдэнэт хот анх байгуулагдаж байх үедээ 7800 хүнтэй байсан бол өдгөө Орхон аймгийн хүн ам 90 орчим мянга болжээ. Энэ үзүүлэлтээрээ улсынхаа хэмжээнд Улаанбаатарын дараа хоёрдугаар байранд ордог. Хүн амын жилийн дундаж өсөлт 2,2 хувь бөгөөд нийт хүн амын 63,9 хувийг залуучууд эзэлдэг. Аймгийн хүн амын 64,0 хувь нь хөдөлмөрийн насных бөгөөд эдийн засгийн идэвхтэй хүн амын 95,2 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. Нийт иргэдийн 53,0 орчим хувь нь 6 бичил хороололд орчин үеийн тохилог орон сууцанд амьдарч байна.

Өрхийн тоо: 27250

Хүн амын тоо: 99,8 мянга

Улаанбаатар хотоос алслагдсан зай: 365км



ОРХОН АЙМГИЙН

ЭРДЭНЭТ

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБОО

Аялал жуулчлал зочид буудлын "Эрдэнэт" холбоо нь Орхон аймгийн аялал жуулчлал, зочид буудлын үйлчилгээний чанар хүртээмж, түвшинг сайжруулахад чиглэгдсэн бүхий л ажлыг дэмжин бүс орон нутгийн салбарын хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор 2011 онд үүсгэн байгуулагдсан ТББ юм.

Холбооны тэргүүн нь А. Түвшинжаргал, удирдах зөвлөлийн гишүүд нь Орхон аймагт үйл ажиллагаа эрхэлдэг зочид буудал, жуулчны бааз, амралтын газар, ресторан, аялал жуулчлалын хөтөч, компаний төлөөлөл бүхий 11 гишүүний бүрэлдэхүүнтэй.

Тус холбоо нь аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж тухайн чиглэлийн сургалт, судалгааны ажил, хөтөлбөрүүдийг зохион байгуулахад нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн оролцоо, идэвхийг дэмжих, мэдээллийг хүртээмжтэй хүргэх чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа зохион байгуулдаг ТББ юм.

ҮЗМЭРҮҮД

ОРХОН АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ЗЭРЭГЛЭЭ

Орхон аймгийн Жаргалант сумын нутагт Эрдэнэт хотоос зүүн урагш 25км зайд, Чингэл гэдэг жижиг голын хойд эрэг дагуу орших араараа модтой толгод, тэгш дэвсгүүдтэй 10 км үргэлжлэх газрыг “Зэрэглээ” хэмээнэ. Чингэлийн голын хөвөөгөөрөө Булган аймагтай хиллэдэг. Голын урд эрэг нь өндөр толгой, модтой уулын ар хэсгээр хүрээлэгдсэн үзэсгэлэнтэй газар байдаг. Энэ газрын гол онцлог нь голын хойд хэсгийн дэвсэг толгодууд нь түүхийн үл хөдлөх дурсгал болох хүрэл ба төмрийн үе (НТӨ I-III), Түрэгийн үе (YI-YIII), дундад зууны (XII-XV зуун) үеийн булш, хиргисүүр, зэл чулуу (балбал), тахилын онгонууд элбэг байдаг. Олон эрин үе, зуунд хамаарах дурсгалууд нэг дор олноороо зэрэгцэн оршдог нь тус газрын гол онцлог бөгөөд 40 гаруй дурсгал байдаг. Засгийн газрын 2008 оны 175-р тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын захирамжаар хамгаалалтанд авсан байна.



ҮЗМЭРҮҮД

ОРХОН АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

АЙРГИЙН ГОЗГОРЫН ХҮННҮГИЙН БҮЛЭГ ДУРСГАЛТ ГАЗАР

Жаргалант сумын төвөөс зүүн тийш 7км зайд орших Айргийн гозгор гэдэг нүцгэн уулын өвөрт орших Хүннүгийн хожуу үеийн бүлэг дурсгал нь том жижиг нийлсэн 118 гаруй бүлэг дурсгал бий. Хүннүгийн хожуу үеийн бүлэг дурсгал ховор бөгөөд Өвөрмонгол, Буриад, Тувагийн нутагт жижиг жирийн иргэдийн иймэрхүү бүлэг дурсгал илэрсэн байдаг. Энэхүү бүлэг дурсгалыг 2007 онд анх музейн ажилтан Л.Ганчимэг, Д.Эрдэнэбаатар, П.Баярбадрах нар нээн илрүүлж, анхны тодорхойлолт, хар зургийг үйлджээ. Энэхүү дурсгал нь аймгийн үл хөдлөх дурсгалын 2010 оны тооллогоор Хүннүгийн үед хамрах дурсгал байх магадлалтайг тогтоож Соёлын өвийн төвийн мэргэжилтэн Д.Даваацэрэнгийн хүсэлтээр аймгийн хамгаалалтанд 2010 онд авсан байна. 2014 онд Монголын үндэсний музейн хөрөнгө оруулалтаар, 2015 онд аймгийн хөрөнгө оруулалтаар малтлага хийж Хүннүгийн хожуу үе буюу Сяньбигийн үед хамаарах булш гэдгээрээ Монголын археологийн салбарт томоохон байр эзлэх дурсгал болохыг тодорхойлжээ.



ҮЗМЭРҮҮД

ОРХОН АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

БӨӨРӨНХИЙ САЙР ХЭМЭЭХ БАЙГАЛИЙН ТОГТОЦ ГАЗАР

Жаргалант сумын төвөөс зүүн урагш 8км зайд Намаржаагийн гозгор гэдэг толгойгоос баруун урагш 2-3 км газарт жалганы аманд байдаг бөөрөнхий чулуу юм. Нутгийнхан “Бөөрөнхий сайр” гэх ба цайвар шаргалдуу өнгөтэй, 3.8м өндөр, 5м урт өндөг шиг хэлбэртэй боржин чулуун хад юм. Хоёр талаас нь харахад ямар ч өөгүй

аварга өндөр мэт харагддаг байна. Ил биш хонхор жалга маягийн газарт байдаг тул алс зайнаас харагдахгүй, ойр орчинд нь өөр ямар нэгэн хад чулуу байдаггүй нь хэрхэн яаж энэ газарт бий болж тогтсон нь сонирхол татдаг байна.



БУСАД ҮЗМЭРҮҮД



МОНГОЛ ЁС ЗАНШЛЫН ЦОГЦОЛБОР

2019 онд “Нүүдэлчин ард түмний ахуй соёл, зан заншил, эх түүхээ сэргээн санах, монгол ахуйтай танилцах, ард иргэд амралт чөлөөт цагаа ая тухтай өнгөрөөх” Монгол Ёс Заншлын цогцолбор байгуулагдсан. Даяаршил өөрчлөлт, шинэчлэлт ярьсан өнөөгийн нийгэмд Монгол түмнийг хүмүүжүүлж ирсэн эртний түүх соёл, эрүүл чийрэг байлгаж ирсэн уламжлалт арга ухаан, таван хошуу мал, түүний цагаан идээ, арьс шир боловсруулалт гээд уламжлалт ахуйг өвлүүлэх санаачилгыг Баян-Өндөр сумын Засаг дарга С.Ганцогт гарган уг бүтээн байгуулалт хийгдсэн.

ХӨХ МОНГОЛ ЦОГЦОЛБОР

“Хөх Монгол цогцолбор” ОНӨААТҮГ нь Монгол орны өргөн уудам нутагт тархан байрласан 21 аймгуудын бүтэц, онцлог, газар зүйн байршил, монгол түмний аж амьдрал, ёс заншлыг харуулсан өнгөрсөн болоод өнөө цагийн түүхийг товчоолон багтаасан баялаг танилцуулгууд, тухайн аймгийн байгалийн гайхамшигийг төлөөлөн нэгэн үзэсгэлэнт тогтцыг уран баримлын хэлбэрээр цогцлон бүтээсэн үзвэрээс бүрдсэн үндэсний цэцэрлэгт хүрээлэн юм. “Хөх Монгол цогцолбор”-т Монгол улсдаа 2-т орох том өв бүтээлийн нэг болох 12,6 метрийн урттай “Тэнгэрийн ташуур” байгууллагын гол танхимд бий. Орчин үеийн тоноглол 5D кино танхимтай. Хоёр давхарт Их Монгол улсын түүхэн үйл явцыг харуулсан ханын дэлгэмэл панорама уран зураг байдаг буюу “Монголын нууц товчоо”-нд зориулсан түүхэн сэдэвт ханын 3D зураг, Цогцолборын дээд хэсэгт дэлхийн бөмбөрцөг байрлах ба түүний нүүр талд Их Монгол улсын эзэнт гүрний газрын зурагтай, бөмбөрцгийг тойроод төрийн есөн хөлт цагаан туг байрладаг билээ.

ИХ ШҮТЭЭН ЦОГЦОЛБОР

Орхон аймгийн Баян-Өндөр хайрханы өвөрт 22 метр өндөртэй Бурхан багшийн сэрэг дүр цогцолборыг 2012 оны 9-р сарын 16-нд бүтээн байгуулсан билээ. Энэхүү цогцолборыг “Эрдэнэт үйлдвэр”-ийн чадварлаг Цутгуурын цехийн хамт олон 3 жилийн турш урлаж бүтээсэн бөгөөд 467 гаруй хэсэг эд ангиас бүрдсэн 87 тонн цэвэр гууль ашиглаж, нийт 330.000 гаруй хуудсан алтаар алтадсан. Уг цогцолбор нь Орхон аймгийн Аялал жуулчлал амралтын “Их шүтээн цогцолбор” ОНӨААТҮГ газар гэж нэрлэгддэг бөгөөд одоогоор сүсэгтэн олонд буян номын үйлийг түгээн дэлгэрүүлэхээс хангайн бүсийн аялагч жуулчдад танилцуулан ажиллаж байна. Эх орны байгалийн үзэсгэлэнт газрууд, цэнгэг устай Хөвсгөл, Архангайн Тэрхийн цагаан нуур, ард түмнийг ивээсэн их шүтээн Очирваань хайрханд мөргөхөөр явах аялалын төв зам дагуу байрладаг учир дамжин өнгөрөх гадаад дотоодын жуулчдыг татаж, Орхон аймгийг сурталчилан таниулах

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУД



ЭРДЭНЭТ ХОТ ОРЧМЫН ЗОЧИД БУУДЛУУД




ЭРДЭНЭТ-ИНН

📍 Орхон аймгийн
Эрдэнэт хот

☎ 70354550
99351252

🌐 facebook.com/erdenetinn/

📄 lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E



ДЭЭДЭС

📍 Орхон аймгийн
Эрдэнэт хот

☎ 70353034
99999978

🌐 facebook.com/deedeshotel/

📄 lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E



САНСАР

📍 Орхон аймгийн
Эрдэнэт хот

☎ 70357927
99352425

🌐 facebook.com/sansarhotel/

📄 lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУД



ЭРДЭНЭТ ХОТЫН ЗООГИЙН ГАЗРУУД



MEASTROS

📍 Орхон аймгийн
Эрдэнэт хот

☎ 99352417

📌 Монгол, Европ, Ази хоол
www.findlocal.com

📍 lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E



ИЙСТ

📍 Орхон аймгийн
Эрдэнэт хот

☎ 99351252

📌 Халуун тогоо
[www.wens.mn/ийс ресторан/](http://www.wens.mn/ийс_ресторан/)

📍 lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E



ТАМИР

📍 Орхон аймгийн
Эрдэнэт хот

☎ 70358600,
99353177

📌 Монгол, Европ хоол
www.facebook.com/tamirhotel/

📍 lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E

ЭВЭНТ БАЯР НААДМУУД

ЭРДЭНЭТ ХОТЫН ӨДӨР

г “Эрдэнэт хотын өдөр”, 2019 оны 76 дугаар тогтоолоор “Анхдагч, илгээлтийн эзэд”-ийн баярын өдрийг хамтатган тэмдэглэж байна. Эрдэнэтчүүд “Эрдэнэт хот байгуулагдсан түүхэн өдөр”-өө тэмдэглэдэг бөгөөд Их хотын аялал, Их хотын хямдрал, ахлах ангийн сурагчдад аймгийн удирдлагууд болон ИТХ-ын төлөөлөгчид хотын үүсэл, түүхийн талаар хичээл заах зэрэг арга хэмжээ явагддаг.

ХУГАЦАА:

Жил бүрийн 12 сарын 11 нд

ХААНА:

Эрдэнэт хот

ХӨТӨЛБӨР:

Эрдэнэт хотын соёлыг түгээх, зууны манлай бүтээн байгуулалттай хотыг бүтээн байгуулсан иргэддээ хүндэтгэл үзүүлэх баяр.

